| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,115,000.00 | 4,815,000.00 | 1,815,000.00 |
| 210104 | Урамшуулал | 264,200,807.00 | 234,765,200.00 | 246,175,553.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 19,627,700.00 | 19,627,700.00 | 16,693,250.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 530,587,190.00 | 563,873,200.00 | 556,904,270.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 361,794,827.00 | 396,786,700.00 | 392,841,449.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 47,510,347.00 | 41,771,700.00 | 40,924,091.12 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 32,005,246.00 | 33,417,300.00 | 32,897,475.33 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,414,428.00 | 8,354,300.00 | 8,133,391.63 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 80,862,342.00 | 83,543,200.00 | 82,107,863.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 669,673,453.04 | 925,580,000.00 | 897,548,005.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 34,127,790.54 | 52,539,100.00 | 48,260,492.77 |
| 210302 | Түлш, халаалт | 626,515,302.50 | 853,086,500.00 | 839,447,393.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,030,360.00 | 19,954,400.00 | 9,840,120.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 105,002,734.00 | 101,256,500.00 | 98,613,843.46 |
| 210401 | Бичиг хэрэг | 25,556,803.00 | 23,034,000.00 | 24,291,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 37,493,240.00 | 34,615,800.00 | 34,919,901.46 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,643,191.00 | 15,457,800.00 | 12,383,602.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,447,800.00 | 6,744,700.00 | 5,614,740.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 24,793,800.00 | 21,404,200.00 | 21,404,200.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 169,493,235.00 | 264,506,000.00 | 216,677,215.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 18,190,000.00 | 19,332,100.00 | 17,332,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 127,047,835.00 | 223,678,300.00 | 178,981,315.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 24,255,400.00 | 21,495,600.00 | 20,363,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,000,600.00 | 84,982,600.00 | 39,589,650.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,000,600.00 | 84,982,600.00 | 39,589,650.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,878,700.00 | 21,697,900.00 | 14,885,250.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,878,700.00 | 21,697,900.00 | 14,885,250.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 158,803,916.00 | 93,447,600.00 | 93,404,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 139,135,400.00 | 85,414,500.00 | 85,403,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 528,952.00 | 5,321,400.00 | 5,308,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 519,600.00 | 519,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 252,080.00 | 254,900.00 | 254,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 76,684.00 | 120,800.00 | 120,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 18,203,400.00 | 1,662,400.00 | 1,659,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138,300.00 | 138,300.00 | 138,300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | 15,700.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 69,742,705.00 | 151,427,700.00 | 123,471,710.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,154,405.00 | 53,000,000.00 | 26,775,850.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 36,588,300.00 | 98,427,700.00 | 96,695,860.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 91,793,700.00 | 124,061,400.00 | 123,154,780.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 91,793,700.00 | 124,061,400.00 | 123,154,780.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 64,146,500.00 | 121,061,400.00 | 120,154,780.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,647,200.00 | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **519,019,932.00** | **380,912,500.00** | **201,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 519,019,932.00 | 380,912,500.00 | 201,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 519,019,932.00 | 380,912,500.00 | 201,000,000.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 121,605,000.00 | 100,000,000.00 | 94,669,697.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 121,605,000.00 | 100,000,000.00 | 94,669,697.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 6,410,361,115.23 | 6,994,423,200.00 | 6,711,892,592.76 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 4,295,406,586.89 | 4,749,828,100.00 | 4,682,696,244.99 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 4,295,406,586.89 | 4,749,828,100.00 | 4,682,696,244.99 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,958,443,819.80 | 1,883,228,900.00 | 1,852,801,000.77 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 1,826,652,534.80 | 1,623,240,000.00 | 1,699,525,489.77 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 131,791,285.00 | 259,988,900.00 | 153,275,511.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 156,510,708.54 | 361,366,200.00 | 176,395,347.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 156,510,708.54 | 103,863,400.00 | 176,395,347.00 |
| 1E+06 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | | 257,502,800.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **96,307,518.50** | - | 80,502,826.50 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **80,502,826.50** | - | 160,776,987.50 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | - | | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 12.00 | 12.00 | 12.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 12.00 | 12.00 | 12.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 318.00 | 318.00 | 234.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 21.00 | 21.00 | 20.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 200.00 | 203.00 | 139.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 95.00 | 92.00 | 67.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 2.00 | 2.00 | 8.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 3,205.00 | 3,176.00 | 1,909.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 2,395.00 | 2,366.00 | 1,066.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 2,395.00 | 2,366.00 | 1,066.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 810.00 | 810.00 | 843.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 810.00 | 810.00 | 843.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **318.00** | **318.00** | **234.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 11.00 | 11.00 | 12.00 |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 248.00 | 278.00 | 193.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 10.00 | 10.00 | 10.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч | 7.00 | 7.00 | 7.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 2.00 | 2.00 | 2.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 40.00 | 10.00 | 10.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **128,059,555.46** | **377,381,527.37** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **128,059,555.46** | **353,500,027.37** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 38,963,097.00 | 211,371,673.64 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 335,850.00 | 721,442.46 |
| 210101 | Үндсэн цалин | | 721,442.46 |
| 210102 | Нэмэгдэл | 335,850.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 923,185.00 | - |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 906,585.00 | |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,000.00 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,360.00 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 840.00 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,400.00 | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,320,974.00 | 3,318,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 12,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,320,974.00 | 3,306,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,171,190.00 | 15,008,724.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 887,915.00 | 2,147,224.60 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,745,915.00 | 7,215,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 50,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 537,360.00 | 5,596,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,820,000.00 | 4,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,820,000.00 | 4,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,213,608.00 | 34,071,382.58 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,213,608.00 | 33,649,034.58 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 390,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 32,348.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,178,290.00 | 154,252,124.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,932,000.00 | 102,203,124.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 246,290.00 | 52,049,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 89,096,458.46 | 142,128,353.73 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 87,446,616.00 | 85,502,278.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 87,446,616.00 | 85,502,278.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,649,842.46** | **56,626,075.73** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 1,649,842.46 | 56,626,075.73 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **23,881,500.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 23,881,500.00 |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 23,881,500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 128,059,555.46 | 377,381,527.37 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 128,059,555.46 | 377,381,527.37 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 86,472,145.46 | 297,276,164.73 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 41,587,410.00 | 80,105,362.64 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Оюунсувд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 1/70 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг дээдлэн төрийн үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд эрх тэгш, хүнд сурталгүй, ил тод шуурхай хүргэж, сум орон нутгийнхаа хөгжил дэвшилд манлайлагч, мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны байгууллага байх зорилго, чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.
Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.
Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сум нь дотоод хяналтын нэгжийг байгуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийлллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн орлого 9,060.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 135.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 101.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

*Мөнгөн хөрөнгө*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 286.2 сая төгрөг болж, өмнөх оноос 38.9 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 79.0 сая төгрөг нь СХС-ийн, 81.7 сая төгрөг нь ОНХС-ийн, 125.4 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

*Авлага*

Авлага дансны үлдэгдэл 475.7 сая төгрөг болж, өмнөх оноос 44.6 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Сум хөгжүүлэх сангийн авлага буурсантай холбоотой байна.

*/төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---:|---:|
| ЗДТГ | 500,000.00 | 500,000.00 |
| ИТХ | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| Ерөнхий боловсролын 2-р сургууль | 7,776,350.00 | - |
| Тосонцэнгэл 1 дүгээр цэцэрлэг | - | 38,183.00 |
| Тосонцэнгэл 2 дугаар цэцэрлэг | 200,000.00 | 200,000.00 |
| Тосонцэнгэл 3 дугаар цэцэрлэг | 8,042,687.86 | - |
| Тосонцэнгэл 5 дугаар цэцэрлэг | 4,463,891.61 | 288,200.00 |
| Тосонцэнгэл 6 дугаар цэцэрлэг | - | 574,867.00 |
| СХС | 497,784,415.00 | 472,558,210.00 |
| **ДҮН** | **520,267,344.47** | **475,659,460.00** |

*Бараа материал*

Бараа материалын үлдэгдэл 645.7 сая төгрөг болж, өмнөх оноос 64.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь түүхий эд материал 0.4 сая төгрөгөөр, хангамжийн материал 63.9 сая төгрөгөөр холбоотой байна.

*Үндсэн хөрөнгө*

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 15,061.0 сая төгрөг болж, 3,564.9 сая төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагууд 124.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, 986.8 сая төгрөгийн хөрөнгө хандиваар ирсэн, Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн барилга шинээр ашиглалтад орсон, төсөвт байгууллагууд 907.6 сая төгрөгийн хөрөнгө акталсан, элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна.

*Богино хугацаат өр төлбөр*

Өглөг дансны үлдэгдэл 0.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1.0 сая төгрөгөөр буурсан байна.

/төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| ЗДТГ | 362,960.00 | |
| ИТХ | | 43,419.00 |
| Ерөнхий боловсролын 2-р сургууль | | 134,782.19 |
| Тосонцэнгэл 2-р цэцэрлэг | 98,719.34 | |
| Тосонцэнгэл 4-р цэцэрлэг | 2,402.00 | 2,402.00 |
| Тосонцэнгэл 6-р цэцэрлэг | 6,747.00 | 6,747.00 |
| Ойн анги | 732,756.44 | |
| **ДҮН** | **1,203,584.78** | **187,350.19** |

*Цэвэр хөрөнгө*

Цэвэр хөрөнгийн дүн 16,468.4 сая төгрөг болж, 3,624.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Засгийн газрын оруулсан капитал 0.6 сая төгрөгөөр өссөн, тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 5,807.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж 1,187.4 сая төгрөгөөр нэмж, 6,994.4 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 6,994.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 6,513.5 сая төгрөгийг урсгал зардалд, 380.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 100.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 4,749.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,623.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 260.0 сая төгрөгийг орон  нутгийн хөгжлийн сангаас, 103.9 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 257.5 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,682.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 1,699.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 153.3 сая төгрөг, үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос 176.4 сая төгрөг, нийт  6,711.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 282.5 сая төгрөг дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 176.4 сая төгрөг бүрдүүлж, зээлийн эргэн төлөлт батлагдсан төсвөөс 76.4 сая төгрөгөөр нэмж төлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,631.6 сая төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсон, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 57.9 сая төгрөгийг сумын төсөвт, 59.3 сая төгрөгийг улсын төсөвт, 104.8 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна. зөв

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 12.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 284.8 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 80.1 сая, нийт 377.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 296.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 23.9 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 56.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.
Аудитаар илэрсэн алдаа зөрчил нь төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг түвшнээс бага тул зөрчилгүй санал, дүгнэлт өгсөн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс 32 мэдээллийг хугацаа хоцроож, Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 дахь хэсэгт төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах болон 89.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн шийдвэрийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8 дэх заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитаар нийт 147.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 28.5 сая төгрөгийн алдааг залруулж, 29.5 сая төгрөгийн зөрчил 1 заалт зөвлөмж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 89.5 сая төгрөгийн зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

### 4.2.1 Залруулсан алдаа

Төсвийн шууд захирагчийн тайланг нэгтгэхдээ Сум хөгжүүлэх сангийн аудитлагдсан тайланг 28.5 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн алдааг залруулсан.

### 4.2 .2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй

### 4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй

### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1 Хяналттай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u> Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал: Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй /түлш халаалтын зардлаас засвар үйлчилгээ хийсэн г.м/, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ гаргасан, ЗГ-ын 43 дугаар тогтоолыг зөрчин, зардлыг зориулалт бус зарцуулж ажилчдад спорт хувцас, формын хувцас, нормын хувцас худалдан авч өгсөн, шийдвэргүй хөрөнгө бэлтгэсэн, албан томилолтоор ажилласан албан хаагчдын байр хоолны үнийг төсвөөс төлсөн, мал тооллогын зардлаас тэмцээн зохион байгуулсан зэрэг зөрчлүүд байна.*

*Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар*

*зүйлийн 7.13.7 "энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд", 8 дугаар зүйлийн 8.4 "Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж:*

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах;

**2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*Илрүүлэлт:* Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс 32 мэдээллийг хугацаа хоцроож, Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 дахь хэсэгт төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах болон 89.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь хэсэгт төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр мэдээлж хэвших;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

**5. Төвлөрүүлэн захирагчийн зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ЗДТГ | 2 | 5.3 | | | 1 | 1.3 | | | 1 | 4.0 |
| 2 | Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль | 5 | 17.6 | 2 | 14.1 | 1 | 0.5 | | | 2 | 3.0 |
| 3 | Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль | 4 | 95.6 | 1 | 0.1 | 1 | 7.4 | 1 | 14.6 | 1 | .73.5 |
| 4 | Тосонцэнгэл сумын 5 дугаар цэцэрлэг | 3 | 2.1 | 2 | 0.3 | 1 | 1.8 | | | | |
| 5 | Тосонцэнгэл сумын 6-р цэцэрлэг | 2 | 19.5 | | | 1 | 0.5 | 1 | 19.0 | | |
| 6 | Сум дундын ойн анги | 1 | 1.8 | | | | | | | 1 | 1.8 |
| 7 | Тохижилт үйлчилгээний алба | 1 | 0.8 | 1 | 0.8 | | | | | | |
| 8 | Тосон-Очирт хайрхан" ТБОНӨҮГ | 4 | 3.5 | 2 | 0.4 | | | 1 | 2.4 | 1 | 0.7 |
| 9 | Төвлөрүүлэн захирагч | 3 | 147.5 | 1 | 28.5 | | | | | 2 | 119.0 |
| **Дүн** | | **25** | **293.7** | **9** | **44.2** | **5** | **11.5** | **3** | **36.0** | **8** | **202.0** |